

Аудит хийгдсэн байгууллага: "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБА

- ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН.

Аудитын нэр: Байгууллагын дотоод аудит
Жил: 2023 он, 2024 эхний хагас жил

АУДИТ ХИЙСЭН БАЙГУУЛЛАГА: НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБА:

АУДИТ ХИЙГДСЭН БАЙГУУЛЛАГА: ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ГУРАВ ОНӨААТҮГ

АУДИТЫН ТӨРӨЛ: ДОТООД АУДИТ

АУДИТЫН ХУГАЦАА: АЖЛЫН 25 ХОНОГ

ДОТООД АУДИТЫН НЭГЖИЙН ДАРГА: НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН
АЛБАНЫ ДАРГА З.ОТГОНБАЯР

ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА: НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН
АЛБАНЫ АУДИТ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА /СХШУАБ/ Ч.ГҮРБАЗАР

АУДИТЫН БАГИЙН АХЛАГЧ: НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ АХШХ-
ИЙН АХЛАХ ДОТООД АУДИТОР /СХШУАБ/ О.БАЯРМАГНАЙ

АУДИТЫН БАГИЙН ГИШҮҮН: НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ АХШХ-
ИЙН АХЛАХ ДОТООД АУДИТОР Д.МӨНХХАНД

АУДИТЫН БАГИЙН АХЛАГЧ: НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ АХШХ-
ИЙН АХЛАХ ДОТООД АУДИТОР /СХШУАБ/ Б.МЯГМАРЗАЯА

АУДИТЫН БАГИЙН АХЛАГЧ: НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ АХШХ-
ИЙН АУДИТОР М.ХИШИГТ

АУДИТЫН БАГИЙН АХЛАГЧ: НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ АХШХ-
ИЙН АУДИТОР Г.ЭНХЧИМЭГ

АГУУЛГА

1. ТАНИЛЦУУЛГА

2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

2.2 Аудитын цар хүрээ

2.3 Аудитын арга аргачлал

3. Байгууллагын талаар

3.1. Засаглалын удирдлагын талаар

3.2. Эрсдэлийн удирдлагын талаар

3.3. Дотоод хяналтын талаар

3.4. Өмнөх хяналт шалгалтын талаар

3.5. Санхүүгийн үйл ажиллагааны талаар

4. АУДИТЫН ҮР ДҮН

4.1. Илэрсэн асуудлууд

5 НЭГДСЭН ДҮГНЭЛТ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
УБ	Улаанбаатар
НИТХ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын тамгын газар
НДАА	Нийслэлийн Дотоод аудитын алба
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
НӨХГ	Нийслэлийн Өмчийн харилцааны газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
АО	Ажил олгогч
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ТБОНӨХБАҮХАТХууль	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
БНХАУ	Бүгд найрамдах хятад ард улс
ИТА	Инженер техникийн ажилчид
ХХБ	Худалдаа хөгжлийн банк
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ББНШК	Бичиг баримт нягтлан шалгах комисс
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
АХШХ	Аудит хяналт шалгалтын хэлтэс
ТШББ	Тендер шалгаруулах баримт бичиг
ЗУХНХ	Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтэс

1. ТАНИЛЦУУЛГА

Төсвийн тухай хуулийн 69.1 дэх хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8.2 дахь заалт, Засгийн газрын 2015 оны "Дүрэм батлах тухай" 483 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 15 дугаар удирдамжийн дагуу Аудит, хяналт шалгалтын хэлтсийн ахлах дотоод аудитор О.Баярмагнай, Д.Мөнхханд, Б.Мягмарзаяа, дотоод аудитор М.Хишигт, Г.Энхчимэг нар ажлын 25 хоногт аудит, хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн.

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

2.1 . Аудитын зорилго:

"Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа нь төсөв, санхүү, өмч хөрөнгөтэй холбоотой Монгол улсын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан заавар, журамтай нийцэж буй эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангахад оршино.

2.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

Дотоод аудит, хяналт шалгалтын удирдамжийн зорилгыг хангахад дараах зорилтуудыг хэрэгжүүллээ. Үүнд:

Дотоод аудит:

- Байгууллагын засаглал;
- Эрсдэлийн удирдлага;
- Дотоод хяналтын үйл явцыг үнэлэх;
- Өмнөх хяналт шалгалтын талаар

- Санхүүгийн үйл ажиллагааны талаар.

Хяналт шалгалт:

Санхүүгийн хяналт шалгалтад тус газрын 2023 он, 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд дараах үйл ажиллагааг хамруулан шалгалаа. Үүнд:

- Санхүү, төсөв, өмч, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль, тогтоомж, түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт;
- Худалдан авах ажиллагаатай холбоотой үйл ажиллагаа;
- Байгууллагын дотоод журам, удирдлагын тушаал, бусад байгууллага хувь хүнтэй байгуулсан гэрээ, хэлцэл нь хууль эрх зүйн үндэслэлтэй хийгдсэн эсэх, тэдгээрийн хэрэгжилт;
- Батлагдсан зорилтот түвшин түүний зарцуулалт, өөрийн орлогын төлөвлөгөө, биелэлтийн байдал;
- Тус байгууллагын бүтэц орон тоо, цалин хөлсний тогтоолт олгосон байдал;
- Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, олж бэлтгэсэн байдал, тооллого, тооцоо бодолт;
- Санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, үр ашгийн байдал;
- Төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэгийн зарцуулалт;
- Хөрөнгө оруулалтын ашиглалт, зарцуулалт;

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000

- Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, баримтын бүрдүүлэлт, боловсруулалт, санхүүгийн мэдээ, тайлан гаргалтын байдал;
- Гадаад, дотоодын байгууллага, иргэдээс өгсөн зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалтын байдал;
- Татаар, нийгмийн даатгалын шимтгэл, ногдол ашиг зэрэг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн төвлөрүүлэлтийн байдал;
- Байгууллагын авлага, өр төлбөрийн үүсэн байдал, барагдуулалт, тооцоо нийлсэн актаар баталгаажсан эсэх;
- Байгууллагын нягтлан бодогчийн хууль тогтоомжид заасан үүргийн биелэлтийг хамруулан шалгалаа.

Хязгаарлалт: Байгууллагын авлага, өр төлбөрийн тулган баталгаажуулалтыг хязгаарласан болно.

2.3 Аудитын арга, аргачлал

Дотоод аудитаар байгууллагын удирдлагад дотоод аудитын зорилго, хэрэгжүүлэх зарчмаа танилцуулж, засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын тогтолцооны талаар асуулга авсан. Аудитын хамрах хүрээнд багтаасан асуудлуудын хүрээнд байгууллагаас олж авсан мэдээлэл, бичиг баримтад дүн шинжилгээ хийж, түүврийн аргаар сорил хийлээ. Аудитын эдгээр горимын үр дүнд, дотоод аудитын баг хангалттай аудитын нотолгоо цуглуулж, аудитын дүгнэлтээ гаргасан болно. Дотоод аудитыг хэрэгжүүлэхэд дараах хууль эрх зүйн баримтуудыг эх үүсвэр болгон ашиглалаа.

- Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт
- Улсын салбарын дотоод аудитын гарын авлага
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- ТБОНӨХБАҮХАТХууль
- Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 311 дүгээр тогтоол
- Монгол Улсын Засгийн Газар, төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас баталж гаргасан холбогдох эрх зүйн баримт бичгүүд, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, нийслэлийн Засаг даргын баталсан дүрэм журам.

3. БАЙГУУЛЛАГЫН ТАЛААР

Байгууллагын онцлох үйл ажиллагаа:

2023 оны онцлох үйл ажиллагаа

- НЗД-ын 2023 оны А/881 тоот тушаалаар БНХАУ-д үйлдвэрлэсэн Xiamen XML6105J15C загварын 100 ширхэг их багтаамжийн автобус орлогод авч үйлчилгээнд нэвтрүүлснээр 12 дугаар сарын байдлаар ажлын өдөрт 120 гаралтаар ажиллаж 43,890 цаг гүйцэтгэж 1 дүгээр сараас гүйцэтгэлийг 90 гаруй хувиар нэмэгдүүлсэн.

- Ажилтны нийгмийн баталгааг хангах хүрээнд 1 ажилтанд байрны урьдчилгаа, 1 ажилтанд Монгол гэр, 1 ажилтанд Сургалтын төлбөр болон тэтгэмж, буцалтгүй тусламжид 101 гаруй сая төгрөг олгосон.

2024 оны онцлох үйл ажиллагаа

- Нийтийн тээврийн парк шинэчлэлтийн хүрээнд орж ирсэн Yutong маркийн 32 ширхэг том оврын автобус, 17 ширхэг County маркийн дунд оврын автобусаар парк шинэчлэлт хийсэн.
- НИТХ-ын шийдвэрээр жолоочийн дундаж цалинг 3,5 сая болгож, ИТА болон бусад ажилчдыг байгууллагаас шат дараатай нэмэгдүүлж дунджаар 2 дахин нэмэгдүүлсэн.
- 2024 оны 5 сард түрээсийн байрнаасаа нүүж шинээр баригдаж буй баазруу нүүж орсон.
- Байгууллагын хэмжээнд хамгийн өндөр цагийн гүйцэтгэлийг 2024 оны 5 сард 67080 цагаар гүйцэтгэсэн.
- 2023 онд ажилчдаас удаан хугацаанд тогтвор суурьшилтай үр бүтээлтэй ажиллаж шагнуулсан 2 ажилтанд **иж бүрэн монгол гэр**, 2 ажилтанд **байрны урьдчилгаа**, 1 ажилтанд **сургалтын төлбөрийг** 2024 онд олгосон.

3.1. Засаглалын талаар

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 73 дугаар тогтоолоор Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ байгуулагдсан. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 28 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар тус газрын дүрмийг шинэчлэн баталсан байна.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн "Удирдах зөвлөл болон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилох тухай" 17 дугаар тогтоолын хавсралтаар тус байгууллагын ТУЗ-ийн гишүүдийг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилсон байна.

"Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын дарга Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын захиралтай байгуулах онцгой нөхцөл бүхий 2023/04 дугаар хөдөлмөрийн гэрээ байгуулсан байна.

Нийслэлийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн "Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын захиралтай байгуулсан 2022 оны Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшний биелэлт болон 2023 оны "Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот" түвшин батлах тухай" А/688 дугаар захирамжаар 2022, 2023 оны Эдийн засаг, санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшинг тус тус баталсан байна.

НЗД-ын 2020 оны 11 дүгээр сарын 27 өдрийн Б/213 дугаар захирамжаар О.Ганбаатарыг Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын дарга, Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын даргын 2021 оны 09 дүгээр сарын 30-ны Б/342 дугаар тушаалаар Б.Баярцэцэгийг санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогчоор томилсон байна. Голомт банкны 5 данс, ХХБанкны 1 данс, нийт 6 дансаар бэлэн бус төлбөр тооцоог хийж, хөрөнгө, мөнгийг захиран зарцуулжээ.

Байгууллагын дүрмийн талаар:

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 28 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар тус газрын дүрмийг шинэчлэн баталсан байна.

1. Дүрмээр "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ нь өөрийн балансад бүртгэгдсэн эд хөрөнгө энэхүү дүрмээр хүлээсэн эрх, үүргийн хүрээнд улс, орон нутгийн төсвөөс олгогдсон хөрөнгө оруулалтаар болон бусад үйл ажиллагааны орлогоор санхүүжих замаар бие даан иргэний гүйлгээнд ордог нийтийн тээврийн хэрэгслээр зорчих, үйлчлүүлэх эрэлт, хэрэгцээг хангах орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар мөн" гэж баталжээ.

2. ОНӨААТҮГ нь Эрхэм зорилгоо "Нийслэлийн иргэд, зорчигчдын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг орчин үеийн төвшинд хүргэж хөгжүүлэх чанар, үр дүнг дээшлүүлэх, иргэдэд шуурхай, боловсон ая тухтай үйлчлэх, хөрөнгө оруулалтын үр дүнг дээшлүүлэх, үйлчилгээний менежментийг сайжруулах төсөл хэрэгжүүлэх, хэтийн төлөвийг тодорхойлох замаар Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээг олон улсын жишигт хүргэх" гэж тодорхойлжээ.

3. Тус дүрмээр "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ нь дараах үйл ажиллагааны үндсэн чиглэлийг: Нийтийн тээврийн үйлчилгээний стандартыг мөрдөж, үйлчилгээний ёс зүйн хэм хэмжээ, хууль тогтоомж, дүрэм, журмыг чанд баримтлан үйл ажиллагааны хувьд ашигтай ажиллах болно. Үүнд:

3.1. Нийслэлийн иргэдэд нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг тав тухтай, аюулгүй байдлыг хангасан нийтийн тээврийн хэрэгслээр хүргэх;

3.2. Нийтийн зорчигч тээврийн хэрэгслүүдэд хийх их болон урсгал засварын нэгдсэн төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, ашиглалтад хяналт тавих;

3.3. Нийтийн зорчигч тээврийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах хүний нөөц (инженер, мэргэшсэн жолооч, засварчин)-ийг бэлтгэх, мэргэжил боловсролыг дээшлүүлэх чиглэлээр сургалтын үйл ажиллагаа явуулах;

3.4. Улаанбаатар хотын нийтийн тээвэрт орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, ашиглалтын ажлыг удирдан зохион байгуулж гүйцэтгэлд хянах" гэж тус тус тодорхойлсон байна.

Байгууллагын бүтэц, орон тооны талаар:

Нийслэлийн засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын бүтэц орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай" А/1332 дугаар захирамжаар "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын орон тооны хязгаарыг 791 албан хаагчтай байхаар баталж, "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ даргын 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн "Үйлдвэрийн газрын бүтэц орон тоог шинэчлэн батлах тухай" А/01 дүгээр тушаалаар 5 хэлтэс, 573 албан хаагчидтайгаар үйл ажиллагаа явуулахаар баталсан.

Байгууллага нь 2023 онд 5 хэлтэс, 397 албан хаагч, инженер техникийн ажилтантайгаар хотын төвийн 13, хот орчмын 8, нийт 21 чиглэлд ажлын өдөр 116, амралтын өдөр 97 шугамын 116 гаралтыг 175 хөдлөх бүрэлдэхүүнтэй, Нийслэлийн зорчигч тээврийн нийт гаралт 12.5 хувь байна.

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000

2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар 605 албан хаагчтай ажиллахаар баталж 448 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллан, 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/15 дугаар тушаалаар 5 хэлтэс, 736 хүний бүрэлдэхүүнтэй бүтэц орон тоог баталж үүнд "Нийтийн тээврийн автобусны жолооч 340" гэснийг "Нийтийн тээврийн автобусны жолооч-470" гэж, "Тээвэр хөдөлгөөн зохицуулагч-6" гэж тус тус өөрчлөн 563 ажилтантайгаар хотын төвийн 15, хот орчмын 6, нийт 21 чиглэлд ажлын өдөр 141 гаралтаас шугамын 133, сургуулийн 8, амралтын өдөр 109 гаралтыг 159 хөдлөх бүрэлдэхүүнтэй, Нийслэлийн зорчигч тээврийн нийт гаралт 11.8 хувь байна.

Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ийн даргын 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/08 дугаар тушаалаар Хөдөлмөрийн дотоод журмыг баталж ажилласан байна.

Хүний нөөцийн хөдлөлийн тайлан

Хүснэгт 1

д/д	Огноо	Оны эхэнд	Нэмэгдсэн	Хасагдсан	Оны эцэст
1	2	3	4	5	6
1	2023	309	265	194	380
2	2024.06.30	380	231	63	548

Аудитад хамрагдах хугацаанд 2023 онд 328-380 ажилтан, 2024 оны эхний хагас 2 сард 430, 3 сард 496, 6 сард 563 ажилтан ажилласан байна. Тус байгууллагад 2024 оны эхний хагас жилээр Нийтийн тээврийн автобусны жолооч нарын тоог 203-аас 296 жолооч болж, Тээвэр хөдөлгөөн зохицуулагч нар 6-аас 11 хүн болон ажилласан.

3.2. Эрсдэлийн удирдлагын талаар:

"Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын Дотоод хяналт, шалгалтын хэлтсийн даргаас авсан "Байгууллагын эрсдэлийн удирдлагын талаар нарийвчилсан асуулга"-аар эрсдэлийн удирдлагын бодлого журамгүй, эрсдэлийг бүртгэж, үнэлж, албажуулдаггүй гэсэн хариуг өгсөн.

Тус байгууллага нь эрсдэлийн удирдлагын бодлого, журам боловсруулаагүй, байгууллагын эрсдэлийн удирдлагын үйл явцыг үнэлэхэд хүлээн зөвшөөрөх эрсдэл, эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийн талаар нэгдсэн ойлголт, чиг хандлага, эрсдэлийн мэдээллийг ашиглах зэрэг үнэлэх шалгууруудын түвшин бүрт эрсдэлийн удирдлагыг тодорхойлж, үнэлээгүй байна.

Нийслэлийн онцгой байдлын газрын гал түймэртэй тэмцэх хэлтэстэй "Гал түймэр унтраах тактикийн дадлага, сургалтын төлөвлөгөө"-г хамтран баталж "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын автобус баазад гарсан гал түймрийг унтраах, аврах ажиллагаа явуулах сэдвээр 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдөр 51 ажилтан албан хаагчийг хамруулсан сургалт зохион байгуулагдсан байна.

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны байнгын комиссыг 2018 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн тушаалаар томилон, Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны үзлэг шалгалтыг 2023 онд 24 удаа, техникийн бүрэн бүтэн байдлын үзлэгийг 9 удаа хийж, илэрсэн зөрчлийг өглөөний шуурхайд мэдээлж, биелэлтэд хяналт тавин ажиллаж, үйлдвэрийн осол бүртгэгдээгүй.

3.3.Дотоод хяналтын талаар

"Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын даргын 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн "Үйлдвэрийн газрын бүтэц орон тоог шинэчлэн батлах тухай" А/01 дүгээр тушаалаар Дотоод хяналт, шалгалтын хэлтсийг Хэлтсийн дарга 1, Ахлах ажилтан 1, Хяналтын ажилтан 3, Хяналтын оператор 4, Шалгалт, үйлчилгээний ажилтан 20, бүгд 29 хүний бүрэлдэхүүнтэйгээр баталсан байна.

Нийслэлийн "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын даргын 2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн "Дотоод хяналт, шалгалт зохион байгуулах журмыг шинэчлэн батлах тухай" А/18 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журам"-ыг баталсан.

Тус газар нь дотоод хяналт, шалгалтын хэлтсийн 2023, 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлан ажилласан. Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөг батлан гаргаагүй, тус хэлтсийн төлөвлөгөөнд тусгаснаар хяналт шалгалтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Дотоод хяналт шалгалтын хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөө

Хүснэгт 2

д/д	Он	Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо
1	2023	29
2	2024	33

Тус хэлтсийн төлөвлөгөөнд 2023 онд 5 зорилтын хүрээнд 29 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг ханган ажилласан. Хэрэгжүүлсэн арга хэмжээний хувьд 27 арга хэмжээ 100%, 1 арга хэмжээ 80%, 1 арга хэмжээ 50%-ийн гүйцэтгэлтэй хийгдсэн байна.

Тусгагдсан зорилт 3.1 дэх "Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтсийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх", 3.6 дахь "Санхүү, бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх", 3.9 дэх "Тээвэрлэлт, үйлчилгээний хэлтсийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх", 3.11 дэх "Техник, технологийн хэлтсийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх" 4 арга хэмжээнд газрын даргын удирдамжийн дагуу хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

3.1 дэх – Газрын даргын 01 дүгээр удирдамжийн дагуу ЗУХНХ-ийн нэгдүгээр улирлын үйл ажиллагааг 15 үзүүлэлтээр 83,5%-иар үнэлэн, 14 ажлыг хийж хэрэгжүүлэхээр зөвлөмж хүргүүлсэн.

3.6 дахь – Санхүү, бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж, 11 ажлыг хийж хэрэгжүүлэхээр 2023 оны 12 дугаар сарын 15-ны дотор хариуг ирүүлэхээр зөвлөмжийг хүргүүлсэн ч хариуг ирүүлээгүй байна.

3.9 дэх – Тээвэрлэлт, үйлчилгээний хэлтсийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж 73%-иар үнэлэн, 15 ололттой, 19 сул тал, ажил сайжруулах 14 зөвлөмжийг хүргүүлэн, 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор хариу ирүүлэхийг зөвлөсөн ч хариу ирүүлээгүй.

3.11 дэх – Тус хэлтсийн үйл ажиллагааг 2023 оны эхний хагас жилийн байдлаар удирдамжид тусгагдсан 9 дэд шалгуурын хүрээнд 72%-ийн гүйцэтгэлтэй буюу цаашид

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000

эрчимжүүлэн ажиллах шаардлагатай гэж үнэлсэн байна. Шалгалтын зөвлөмжийн хариуг хугацаанд нь ирүүлсэн байна.

Өмнөх хяналт шалгалтын талаар

Тус газрын 2023 оны санхүүгийн тайланд Нийслэл дэх Төрийн аудитын газрын гэрээт "Мэдээлэл Аудит" ХХК аудитыг хийж гүйцэтгэн өөрчлөлтгүй санал дүгнэлт хүргүүлсэн байна. Аудитаар нийт 42,703.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1,174.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 26,046.6 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 2 албан шаардлага хүргүүлж, 15,482.9 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн байна.

Нийслэлийн Дотоод аудитын газар тус газрын 2021 он, 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хийж 5 зөвлөмж өгсөн.

Зөвлөмжийн хэрэгжилт

Хүснэгт 3

Д/А	Зөвлөмж	Хэрэгжилт
1	2	3
1	Архивын үйл ажиллагаа болон албан хэрэг хөтлөлтийг сайжруулах, архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомжийг мөрдөж ажиллах	ББНШКомиссыг 2022.04.28-ны өдрийн А/36 тоот тушаалаар шинэчлэн баталж 3 удаа хурал зохион байгуулсан. Газрын даргын 2022.10.10-ны өдрийн А/57 тоот тушаалаар батлагдсан тооллогын комисс нь архивын баримтад тооллого явуулж устгах баримтаа ялган байнга, 70 жил, түр, устгах баримтын жагсвалтыг үйлдэж байна.
2	Байгууллагын авлагын дансанд 2-оос дээш жилийн нэсжилттэй авлагыг барагдуулж ажиллах	2-оос дээш жил болсон 11 ажилтнуудын 34,494,374.28 төгрөгийн авлагаас Э.Энхбат, Г.Алтанхуяг нарын 22,255,456.87 төгрөгийн авлагыг шүүхээр эцэслэн шийдвэрлүүлж, 9 ажилтны 12,238,917.41 төгрөгийн хохирлыг барагдуулахаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна.
3	Захиргааны ерөнхий хуулийн 103.1. "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" заалтыг мөрдөж ажиллах	СХД-ийн прокурорын газраас СХД-ийн ИХАШШүүхэд нэхэмжлэл гарган хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна.
4	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт шинэчлэн найруулагдсан хууль тогтоомж, дүрэм журмыг тухай бүр тусгаж өгөх	Газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/25 тушаалаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажилласан.
5	Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн 60 ш каунти, дүү мөрийн автобус, хүүхдийн 5 автобусны өр эргэн төлөгдөх эсэх нь тодорхойгүй байгаа асуудлыг эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэх	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн 30 дүү автобусны өр төлбөр болох 2,278,526,600 төгрөг нь 2018 онд балансаас балансад шилжин ирж 2019-2022 онуудад хянан хэлэлцэгдэж 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 001/ШХТ2022/01371 дугаартай Монгол улсын дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны тогтоолоор нэхэмжлэгч нарт олгохоор болсон.

3.5. Санхүүгийн тайлангийн талаар:

Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ийн 2023 оны санхүүгийн байдлын тайланд нийт хөрөнгийн дүн 48,323,058.3 мянган төгрөг, 2024 оны эхний хагас жилд 56,277,388.1 мянган төгрөг байна.

2023 оны санхүүгийн байдлын тайлангаар 2,377,430.9 мянган төгрөгийн эргэлтийн, 45,945,627.3 мянган төгрөгийн эргэлтийн бус, нийт 48,323,058.3 мянган төгрөгийн хөрөнгө тайлагнасан байна.

2024 оны эхний хагас жилд санхүүгийн байдлын тайлангаар 5,717,925.4 мянган төгрөгийн эргэлтийн, 50,559,462.7 мянган төгрөгийн эргэлтийн бус, нийт 56,277,388.1 мянган төгрөгийн хөрөнгө тайлагнасан байна.

Хүснэгт 4 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	2023 он			2024 оны эхний хагас	
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт /3-2/	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт /5-3/
1	2	3	4	5	6
Мөнгөн хөрөнгө	216,887.3	504,148.0	287,460.7	12,905.5	(491,242.5)
Авлага	162,187.9	210,726.7	48,538.8	3,983,832.7	3,773,106.0
Урьдчилж төлсөн зардал	95,806.3	97,296.2	1,489.9	262,474.5	165,178.3
Бараа материал	1,161,638.7	1,565,260.1	403,621.4	1,453,686.7	(111,573.4)
Эргэлтийн хөрөнгийн дүн	1,638,320.2	2,377,431.0	741,110.8	5,712,899.4	3,335,468.4
Үндсэн хөрөнгө	24,497,005.8	45,670,000.6	21,172,994.7	50,283,836.0	4,613,835.4
Биет хөрөнгө	0.0	0.0	0.0	0.0	0.0
Биет бус хөрөнгө	275,626.7	275,626.7	0.0	275,626.7	0.0
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	24,772,632.5	45,945,627.3	21,172,994.7	50,559,462.7	4,613,835.4
Нийт хөрөнгө	26,408,952.7	48,323,058.3	21,914,105.5	56,272,362.1	7,949,303.8
Өр төлбөр	35,213,988.3	55,615,703.5	20,401,715.2	58,724,797.1	3,109,093.7
Засгийн газрын сан	2,341,223.0	2,341,223.0	0.0	2,341,223.0	0.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	287,249.0	287,249.0	0.0	287,249.0	0.0
Хуримтлагдсан үр дүн	(11,433,507.6)	(9,921,117.2)	1,512,390.4	(5,080,907.1)	4,840,210.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө, өмчийн дүн	26,408,952.7	48,323,058.3	21,914,105.5	56,272,362.1	7,949,303.8

2023 оны санхүүгийн байдлын тайлангаар өмнөх оны үлдэгдлээс авлага 48,538.8 мянга, бараа материал 403,621.4 мянга, үндсэн хөрөнгө 21,172,994.7 мянга, өр төлбөр 20,401,715.2 мянган төгрөгөөр өссөн байна.

2024 оны эхний хагас жилийн санхүүгийн байдлын тайлангаар өмнөх оны үлдэгдлээс авлага 3,773,106 мянган төгрөгөөр өссөн, бараа материал 111,573.4 мянган төгрөгөөр буурсан, үндсэн хөрөнгө 4,613,835.4 мянган төгрөгөөр, өр төлбөр 3,109,093.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд Ординат ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн Unicus программыг ашиглаж бүртгэлийг хөтөлсөн байна.

Аялагын талаар:

Тус газрын 2023 оны авлага дансны эхний үлдэгдэл 257,996.2 мянга, 2023 оны эцсийн үлдэгдэл 308,027.9 мянга, 2024 онд 4,246,307.2 мянган төгрөгийн үлдэгдэл тайлагнасан байна.

Хүснэгт 5

Авлага

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	2023 он				2024 оны эхний		
	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
1	2	3	4	5	6	7	8
Хувь хүмүүсээс авах авлага	0.00	4,052.8	4,052.8	0.00			
Байгууллагаас авах авлага	94,631.1	24,618,690.5	24,017,413.4	95,908.2	24,958,800.7	21,202,379.7	3,852,329.2
Байгууллагаас авах авлагын түр данс	0.00	2,883,601.3	2,674,594.7	9,008.8	0.00	9,008.8	0
Ажилчидтай холбоотой авлага	11,810.4	640,892.4	601,067.0	51,635.9	546,892.3	521,899.1	81,451.82
Халагдсан хүмүүсээс авах авлага	55,748.2	13,083.2	14,653.7	54,175.6	0.00	747.4	53,428.3
НДШ,ЭМД-ын урьдчилгаа	-	-	-	-	30,098.6	28,652.6	1,445.9
Урьдчилж төлсөн зардал	85,908.2	307,080.4	318,125.2	74,861.5	283,368.4	128,289.7	228,941.2
Урьдчилж төлсөн тооцоо	0,900.0	646,687.9	634,153.1	22,434.7	298,504.8	287,408.2	33,533.3
Нийт авлага	257,996.2	28,314,091.9	28,264,064.1	308,027.9	26,117,665.9	22,179,381.6	4,251,333.2

2023 оны авлага дансны үлдэгдэл 308,027.9 мянган төгрөг болж 50,031.7 мянган төгрөгөөр өссөн нь Нийтийн тээврийн үйлчилгээний газрын зардлын зөрүү санхүүжилтийн авлага 61,172.4 мянган төгрөг, Улаанбаатар смарт карт ХХК-иас авах шугамын үйлчилгээний орлого 34,735.8 мянган төгрөг болон замд яваа мөнгө 9,006.7 мянган төгрөг, ажилчидтай холбоотой авлага 105,811.7 мянган төгрөг, Агула даатгалд урьдчилж төлсөн даатгалын төлбөр 74,861.5 мянган төгрөг, Анир И Эл Эс ХХК-д программын төлбөр 19,800.0 мянган төгрөг, Энх-Аргалжин ХХК-д вирусын программын төлбөр 2,634.7 мянган төгрөгийн авлагатай холбоотой байна.

2024 оны эхний хагас жилийн байдлаар 3,943,106.78 мянган төгрөгөөр өссөн байна. Үүний байгууллагаас авах авлага нь 3,756,421 мянган төгрөгөөр өссөн байгаа нь Нийтийн тээврийн газраас авах орлогоос үүссэн авлага байна. Мөн ажиллагсадтай холбоотой авлага өндөр байна. Үүнээс 26,177.952 мянган төгрөгийн авлага нь Ц.Бямбадоржоос /ХБ79121574/, 11,132.194 мянган төгрөгийн авлага нь Э.Эрдэнэбат /УУ89050837/ төгрөгийн авлага байна.

Өр төлбөрийн талаар:

Тус газрын 2023 оны өр төлбөр дансны эхний үлдэгдэл 35,213,988.10 мянга, эцсийн үлдэгдэл 55,615,703.50 мянга, 2024 онд эцсийн үлдэгдлийг 58,724,796.80 мянган төгрөгөөр

тайлагнасан байна.

Хүснэгт 6

Өглөг

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	2023 он			2024 оны эхний хагас	
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт /3-2/	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт /5-3/
1	2	3	4	5	6
Дансны өглөг	940,382.60	667,560.30	272,822.30	1,981,211.10	-1,313,650.80
Цалингийн өглөг	-	-	-	15,516.20	-15,516.20
Төтвөрын өр	832,140.70	419,781.10	412,359.60	1,351,854.40	-931,873.30
НДШ-ийн өглөг	1,670,646.70	168,705.30	1,501,941.40	642,709.80	-474,004.30
Хүүний өглөг	61,504.50	25,144.50	36,360.00	7,880.70	17,263.80
Ногдол ашгийн өглөг	-	392,197.70	-392,197.70	232,197.70	160,000.00
Урьдчилж орсон орлого	14,370,244.40	43,314,614.90	-28,944,370.50	40,983,742.40	2,330,872.50
Бусад богино хугацаат өглөг	2,547.90	4,482,173.80	-4,479,625.70	1,123,833.80	3,358,339.80
Бусад урт хугацаат өр төлбөр	17,336,521.30	6,145,526.10	11,190,995.20	12,386,050.90	-6,240,524.80
Нийт өр төлбөр	35,213,988.10	55,615,703.50	-20,401,715.40	58,724,796.80	-3,109,093.30

2023 онд байгууллагад төлөх өр төлбөр 272,822.3 мянган төгрөг, ААНОАТ, ХХОАТ-ын өр төлбөр 412,359.6 мянган төгрөг, НДШ-ийн өр төлбөр 1,501,941.4 мянган төгрөг, хүүний өр төлбөр 36,360.0 мянган төгрөг, УХӨТ 11,190.9 мянган төгрөгөөр буурсан, УОО 28,944.4 мянган төгрөг, банкны зээлийн өр төлбөр 4,479.6 мянган төгрөгөөр өссөн байна.

2023 оны өр төлбөрийн эцсийн үлдэгдэл 55,615,703.50 мянган төгрөг байна. Үүнээс 43,314,614.90 мянган төгрөг нь урьдчилж орсон орлого, 6,145,526.10 мянган төгрөг нь бусад урт хугацаат өр төлбөрөөр бүртгэгдсэн байна. Урьдчилж олсон орлогоор 26,364,880.12 мянган төгрөг нь Хиамен автобусны хөрөнгө оруулалт, 896,388.88 мянган төгрөг нь сургуулийн автобусны хөрөнгө оруулалт, 16,053,345.90 мянган төгрөг нь цахилгаан автобусны хөрөнгө оруулалт байна. Бусад урт хугацаат өр төлбөрөөр бүртгэгдсэн 6,145,526.1 мянган төгрөгийн өр төлбөр нь балансаас балансад шилжин ирсэн өр төлбөр болох нийтийн тээврийн газрын Дэйвоо автобусны өр төлбөр байна.

2024 оны өр төлбөрийн эцсийн үлдэгдэл 58,724,801.80 мянган төгрөг байна. Үүнээс 40,983,742.4 мянган төгрөг нь урьдчилж орсон орлого, 12,386,050.9 мянган төгрөг нь бусад урт хугацаат өр төлбөрөөр бүртгэгдсэн байна. Урьдчилж олсон орлогоор 25,001,179.5 мянган төгрөг нь Golden dragon автобусны хөрөнгө оруулалт, 768,333.3 мянган төгрөг нь сургуулийн автобусны хөрөнгө оруулалтаар 15,214,229.6 мянган төгрөг нь цахилгаан автобусны хөрөнгө оруулалт байна. Бусад урт хугацаат өр төлбөрөөр бүртгэгдсэн 12,386,050.9 мянган төгрөгийн өр төлбөр нь балансаас балансад шилжин ирсэн өр төлбөр болох 6,145,526.1 мянган төгрөг нь нийтийн тээврийн газрын Дэйвоо автобусны өр төлбөр, 6,240,524.9 мянган төгрөг нь Yutong маркийн автобусны өр төлбөр байна.

4.2 Бараа материалын талаар:

2023 онд бараа материал дансны эхний үлдэгдэл 1,161,638.69 мянган төгрөг, 11,163,718.6 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 10,760,097.25 мянган төгрөгийн бараа материалыг зарлага болгон, 1,565,260.08 мянган төгрөгийн бараа материалын эцсийн үлдэгдэл тайлагнасан байна.

Хүснэгт 7

Бараа материалын тайлан

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	2023 он			
	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
1	2	3	4	5
Сэлбэг материал /Каунти/	266,832.38	462,448.97	556,272.67	174,008.68
Сэлбэг материал /Экз /	347,341.94	0.00	23,641.37	323,700.57
Сэлбэг материал /Daewoo /	127,949.04	64,701.17	164,474.96	28,175.23
Сэлбэг материал /Аж ахуйн автомашин/	0.00	41,613.20	40,317.20	1,296.00
Сэлбэг материал /Цахилгаан автобус /	66,375.16	868,232.86	372,092.70	562,515.34
Сэлбэг материал -XML6105J15C	0.00	126,910.02	65,977.29	60,932.73
Сэлбэг-Хуучин	0.00	4,079.50	4,079.50	0.00
Сэлбэг материал /Сургуулийн автобус/	0.00	617.00	207.00	410.00
Дугуй	85,958.67	122,613.00	123,004.00	85,567.67
Багаж тоног төхөөрөмж	16,259.02	41,797.20	33,136.51	24,919.71
Шатахуун	11,613.00	8,506,837.56	8,514,648.96	3,601.60
Тос тослох материал	46,755.24	404,675.70	382,439.25	68,991.69
Хөдөлмөр хамгаалалын хувцас хэрэгсэл	53,683.74	132,298.78	172,363.80	13,628.71
Хангамж аж ахуйн материал	33,058.63	146,981.96	169,819.31	10,221.31
Карттай эд хослол	96,409.12	73,733.73	73,246.79	96,896.06
Карттай акрын хувцас	0.00	83,112.00	0.00	83,112.00
Бичиг хэрэг, ном, маягт	5,265.01	50,290.19	55,895.24	5,655.96
Эм тариа боох материал	4,137.74	6,781.75	9,490.67	1,428.82
Нийт	1,161,638.69	11,163,718.63	10,760,097.25	1,565,260.08

2023 оны бараа материалын дансны үлдэгдэл 1,565,260.08 мянган төгрөг болж өмнөх оноос 403,621.39 мянган төгрөгөөр өссөн нь цахилгаан автобусны баталгаат засварын төлөвлөгөөт ажил хийхтэй холбоотой сэлбэгийг нөөцлөн авсантай холбоотой байна.

Хүснэгт 8

Бараа материалын тайлан

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	2024 оны эхний хагас жил			
	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
1	2	3	4	5
Сэлбэг материал /Каунти/	174,006.68	39,989.32	77,319.11	136,676.89
Сэлбэг материал /Экз /	323,700.57	0.00	11,710.60	311,989.97
Сэлбэг материал /Daewoo /	28,175.23	39,392.85	45,278.55	22,289.52
Сэлбэг материал /Аж ахуйн автомашин/	1,296.00	13,203.25	6,763.75	7,735.50
Сэлбэг материал /Цахилгаан автобус /	562,515.34	72,044.25	364,876.52	289,683.07
Сэлбэг материал -XML6105J15C	60,932.73	474,439.52	325,033.92	210,338.34
Сэлбэг материал /Сургуулийн автобус/	410.00	1,144.00	1,144.00	410.00
Сэлбэг материал -Yutong ZK6116HG	0.00	1,463.10	419.60	1,043.50
Дугуй	85,567.67	199,408.10	162,755.26	122,220.51
Багаж тоног төхөөрөмж	24,919.71	11,030.30	16,188.81	19,761.20
Шатахуун	3,601.60	7,370,709.47	7,374,511.07	0.00
Тос тослох материал	68,991.69	210,399.83	258,538.02	20,853.50
Хөдөлмөр хамгаалалын хувцас хэрэгсэл	13,628.71	102,053.40	92,146.04	23,536.07
Хангамж аж ахуйн материал	10,221.31	116,246.50	114,644.72	11,823.09

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ-4000				
1	2	3	4	5
Карттай ад хогшил	96,896.06	25,441.87	6,265.64	116,072.29
Карттай ажлын хувцас	83,112.00	63,484.50	522.50	146,054.00
Бичиг хэрэг, ном, маягт	5,655.96	26,017.20	25,973.29	5,699.87
Эм тариа боох материал	1,426.82	6,919.30	848.79	7,499.33
Нийт	1,565,260.08	8,773,366.76	8,884,940.19	1,453,686.65

2024 оны бараа материалын дансны үлдэгдэл 1,453,686.65 мянган төгрөг болж өмнөх оноос 111,573,643 мянган төгрөгөөр буурсан байна. нь цахилгаан автобусны баталгаат засварын төлөвлөгөөт ажил хийхтэй холбоотойгоор бараа материалын дансанд сэлбэг хэрэгслийн дүн өндөр байна.

4.3 Үндсэн хөрөнгийн талаар:

2023 онд үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 42,382,612.85 мянган төгрөг, 27,352,090.14 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авч, 6,886,013.25 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 16,903,062.36 мянган төгрөгийн хөрөнгийн элэгдлийн зардал байгуулан, 45,945,627.38 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл тайлагнасан байна.

Хүснэгт 9

Үндсэн хөрөнгийн тайлан 2023 он

(мянган төгрөгөөр)

Дансны нэр	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
1	2	3	4	5	6	7
Машин тоног төхөөрөмж	1,950,481.01		67,336.90	1,883,154.10	783,551.62	1,099,602.49
Компьютер дагалдах хэрэгсэл	121,973.70	16,626.21	32,850.30	107,649.61	91,021.90	16,627.71
Тээврийн хэрэгсэл	39,000,457.34	27,333,463.93	6,730,453.25	60,503,468.02	15,967,897.94	44,535,570.08
Тавилга эд хогшил	109,119.10		52,747.80	56,371.30	34,556.40	21,814.90
Бусад үндсэн хөрөнгө	11,438.00		2,525.00	8,910.00	2,524.50	6,385.50
Биет бус хөрөнгө	13,510.00			13,510.00	13,510.00	-
Програм хангамж						
Газар	275,626.70			275,626.70		275,626.70
Нийт	42,382,612.85	27,352,090.14	6,886,013.25	62,848,689.73	16,903,062.36	45,945,627.38

Нийслэлийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн "Тээврийн хэрэгсэл бүртгэн авах тухай" А/881 дүгээр захирамжаар 100 ширхэг их багтаамжийн дизель хөдөлгүүртэй Xiamen XML6105J15C загварын 27,274,013.9 мянган төгрөгийн автобус, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1375 дугаар захирамжаар 59,450.0 мянган төгрөгийн Kia Bongo автомашин, "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын даргын 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн "Үндсэн хөрөнгө данс бүртгэлд орлого авах тухай" А/27 дугаар тушаалаар 15,645.3 мянган төгрөг, "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын даргын 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн "Үндсэн хөрөнгө данс бүртгэлд орлого авах тухай" А/40 дүгээр тушаалаар 2,980.8 мянган төгрөгөөр тоног төхөөрөмжийг орлогоор бүртгэн, Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын "Зорчигч тээвэр гурав" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын данс бүртгэлээс тээврийн хэрэгсэл хасах тухай" 2023 оны 05 дугаар сарын

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000

17-ны өдрийн А/90 дугаар тушаалаар 6,730,453.2 мянган төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий үлдэгдэл өртөггүй 46 ширхэг тээврийн хэрэгсэл, 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/569 дүгээр тушаалаар 155,560.0 мянган төгрөгийн бусад хөрөнгийг данснаас хасах шийдвэр гарсан байна.

Хүснэгт 10

Үндсэн хөрөнгийн тайлан 2024 он

(мянган төгрөгөөр)

Дансны дугаар, нэр	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
Машин тоног төхөөрөмж	1,883,154.11			1,883,154.11	934,190.64	948,963.48
Компьютер датагдлах хэрэгсэл	107,649.61			107,649.61	86,587.82	11,061.80
Тээврийн хэрэгсэл	60,503,468.02	8,831,462.40	2,577,999.60	66,756,930.82	17,458,476.50	49,298,454.32
Тавилга эд хогшил	56,371.28			56,371.28	37,093.37	19,277.91
Бусад үндсэн хөрөнгө	8,910.00			8,910.00	2,621.50	6,088.50
Биет бус хөрөнгө	13,510.00			13,510.00		13,510.00
Програм хангамж						
Газар	275,626.70			275,626.70	13,510.00	262,116.70
Нийт	62,848,689.72	8,831,462.40	2,577,999.60	69,102,152.52	18,542,689.84	50,559,462.69

2024 оны эхний хагас жилд 8,831,462.4 мянган төгрөгөөр нэмэгдэж 2,577,462.4 мянган төгрөгөөр буурсан байна. Үүнд нэмэгдсэн хөрөнгөд НЗД-ын А/86 дугаар захирамжаар их багтаамжийн 16 Yutong автобус 4,415,731.2 мянган төгрөг, НЗД-ын 2024 оны А/588 тоот захирамжаар их багтаамжийн 16 Yutong 4,415,731.2 мянган төгрөг, НЗД-ын А/756 тоот захирамж 20 Hyundai county 8,550.0 мянган төгрөгөөр данснаас хасах шийдвэр гаргасан байна. НӨХГ-ын даргын А/129 тоот тушаалаар 2,577,999.6 мянган төгрөгийн 20 тээврийн хэрэгслийг данс бүртгэлээс хассан байна.

4.5 Орлого, зарлагын зорилтот түвшний талаар:

Нийслэлийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн "Орон нутгийн өмчит аж ахуйн тооцостой үйлдвэрийн газруудын захиралтай байгуулсан 2022 оны Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшний биелэлт болон 2023 оны "Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшин" батлах тухай" А/688 дугаар захирамжаар 2023 оны нийт орлогыг 23,721,476.34 мянган төгрөг, нийт зардлыг 29,080,011.33 мянган төгрөг, алдагдлыг 5,358,534.99 мянган төгрөг, борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал 1,23 төгрөг, тухайн жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 1,095,200.00 мянган төгрөг байхаар баталсан байна.

2023 оны зорилтот түвшний төлөвлөгөөг Нийслэлийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн "Захирамжийн хавсралтад өөрчлөлт оруулах тухай" А/1125 дугаар захирамжаар нийт орлогыг 23,721,476.3 мянган төгрөг, нийт зардлыг 31,307,394.85 мянган төгрөг, алдагдлыг 7,585,918.5 мянган төгрөг, борлуулалтын орлогын нэг төгрөгт ногдох зардлыг 1.3 төгрөг, тухайн жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 1,095,200.00 мянган төгрөгөөр баталсан байна.

2023 онд 30,615,304.46 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 28,363,512.69 мянган төгрөгийн зарлага гарган, 2,251,791.77 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна. Орлогын эх үүсвэр нь санхүүжилт 19,128,460.25 мянга төгрөг, шугамын орлого 2,778,308.00 мянган

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000

төгрөг, нөхөн олговор 2,158,777.94 мянган төгрөг, сургуулийн автобусны орлого 260,241.34 мянган төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 335,235.52 мянган төгрөгөөс бүрдсэн байна.

2023 онд орлогыг 23,721,476.34 мянган төгрөг төлөвлөснөөс 129.1 хувь буюу 6,893,828.12 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн нь шугамын орлого нь нийтийн тээврийн хүн урсгалыг нэмэгдүүлэх картаар зорчих зорчилтыг нэмэгдүүлэх зорилгоор шугамын орлогыг өндөр төлөвлөсөн боловч "Ситибаз консалтинг" ХХК-ийг татан буулгасантай холбогдуулан зорчигчдод хяналт тавих ажилтан багасаж нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын шугамын орлогын түвшин буурч төлөвлөгөө 2,407,587.27 мянган төгрөгөөр тасарсан ч зардлын зөрүү санхүүжилтийн орлого нь 4,496,416.33 мянган төгрөгөөр өссөн байна. 100 ширхэг их багтаамжийн дизель хөдөлгүүртэй Xiamen XML6105J15C загварын автобус авсантай холбогдуулан гаралт нэмэгдсэнээр орлого өсөх шалтгаан болсон.

2023 онд нийт зардал 28,363,512.69 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 90.60 хувийн гүйцэтгэлтэй, 9.4 хувь буюу 2,943,882.16 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна. Тус онд 30,615,304.46 мянган төгрөгийн орлоготой, 28,363,512.69 мянган төгрөгийн зарлагатай, 2,251,791.77 мянган төгрөгийн ашигтай, тайлант үеийн орлогын албан татварын зардал 247,203.21 мянган төгрөг, 2,004,588.56 мянган төгрөгийн тайлант үеийн ашигтай ажилласан байна.

Хүснэгт 11 Төсвийн гүйцэтгэлийн зарцуулалтын талаар (мянган төгрөгөөр)

М	Үзүүлэлт	2023 оны зорилт	2023 оны гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1.	Нийт орлого	23,721,476.34	30,615,304.46	6,893,828.12	129.10%
1.1	Шугамын орлого	5,185,895.27	2,778,308.00	-2,407,587.27	53.60%
1.2	Санхүүжилтын орлого Зардлын зөрүү	14,632,043.91	19,128,460.25	4,496,416.33	130.70%
1.3	Нөхөн олговор - хөнгөлөлттэй зорчилчид	3,111,537.16	2,158,777.94	-952,759.22	69.40%
1.4	Сургуулийн автобусны орлого	720,000.00	260,241.34	-459,758.66	36.10%
1.5	Үйл ажил-ны бусад орлого	72,000.00	335,235.52	263,235.52	465.60%
1.6	Хөсөнгө оруулалтын орлого /ца.автобус/	-	5,954,281.42	5,954,281.42	
2.	Нийт зардал	31,307,394.85	28,363,512.69	-2,943,882.16	90.60%
2.1	Цалин	8,205,148.80	7,582,182.74	-622,966.06	92.41%
2.2	НДШ	1,107,695.08	1,067,610.47	-100,084.61	90.96%
2.3	Шатахуун	8,558,241.98	8,514,965.81	-43,276.17	90.40%
2.4	Тосолгооны материал	1,419,164.78	382,483.43	-1,036,681.35	26.95%
2.5	Салбар хэрэгсэл	1,450,000.00	1,184,670.66	-265,329.32	81.70%
2.6	Дугуйн зардал	232,285.71	122,537.40	-109,748.32	52.75%
2.7	Хөдөлмөр хамгаалал	216,570.22	140,298.96	-76,273.21	64.78%
2.8	Үндсэн хөрөнгийн элэгдэл	6,086,864.79	6,179,095.39	92,230.60	101.52%
2.9	Бичиг хэрэгсэл	48,514.00	33,025.19	-14,588.41	68.93%
2.1	Хангамжийн зардал	73,832.50	55,907.06	-17,925.44	75.72%
2.11	Ариун цэврийн зардал	67,686.15	55,486.46	-12,411.69	81.72%
2.12	Засвар үйлчилгээ	48,300.00	15,794.81	-32,505.19	32.70%
2.13	Цахилгаан	917,436.18	742,392.80	-175,043.68	80.92%

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000

2.14	Ус /Бохир соруулал/	30,000.00	18,200.00	-11,800.00	-60.67%
2.15	Халаалт дулаан	22,500.00	17,352.86	-5,147.14	-22.88%
2.16	Харилцаа холбоо	16,304.00	9,418.26	-6,885.74	-42.23%
2.17	Үндсэн хөрөнгийн татаар	-	-	-	0.0%
2.18	Газрын төлбөр	2,094.20	2,402.69	308.49	14.73%
2.19	Тээврийн хэрэгслийн татаар	24,016.80	22,690.03	-1,326.78	-5.52%
2.2	Даатгалын үйлчилгээ	311,555.02	298,125.23	-13,429.79	-4.31%
2.21	Сургалт, сурталчилгаа	32,700.00	27,542.97	-5,157.03	-15.77%
2.22	Албан томилолт	20,000.00	6,511.59	-13,488.41	-67.44%
2.23	Татварын татгамж,буцалтгүй тусламж	344,889.80	120,812.36	-224,077.44	-65.03%
2.24	Гадны үйлчилгээ	218,590.00	177,862.78	-40,727.22	-18.64%
2.25	Үйл ажиллагааны бусад	123,247.00	92,851.08	-30,395.92	-24.66%
2.26	Түрээсийн зардал	768,000.00	608,850.00	-159,150.00	-20.72%
2.27	Зээлийн хүү /Цахилгаан автобус/	963,545.44	943,566.00	-19,979.44	-2.08%
3. Ашиг, алдагдал		-7,585,918.50	2,251,791.77	9,837,710.27	
Орлогын нэг төгрөгт ногдох зардал		1.32	0.95	-0.37	

Тайлант 2024 оны жилийн нийт орлогын төлөвлөгөө нь 53,451,414.57 төгрөг төлөвлөсөнөөс хагас жилээр гүйцэтгэлээр 29,071,313.58 мянган төгрөг буюу 54.4 хувийн гүйцэтгэлтэй, зарлагын төлөвлөгөө нь 60,629,653.3 мянган төгрөг төлөвлөсөнөөс хагас жилээр 23,665,240.39 мянган төгрөгийн 39 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Хүснэгт 12 Төсвийн гүйцэтгэлийн зарцуулалтын талаар (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт		2024 оны зорилт	2024 оны гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1. Нийт орлого		53,451,414.57	29,071,313.58	24,380,100.99	54.40%
1.1	Шугамын орлого	4,597,505.05	2,564,329.44	2,564,328.44	44.20%
1.2	Санхүүжилтийн орлого Зардлын зөрүү	45,264,844.80	24,161,634.96	24,161,634.96	46.60%
1.3	Нөхөн олговор - хөнгөлөлттэй зорчигчид	3,119,064.72	1,435,503.02	1,435,503.02	54.00%
1.4	Сургуулийн автобусны орлого	350,000.00	162,989.43	162,989.43	53.40%
1.5	Үйл ажил-ны бусад орлого	120,000.00	-58,081.35	-58,081.35	148.40%
1.6	Хөрөнгө оруулалтын орлого /ца.автобус/		-3,886,274.51	-3,886,274.51	0%
2. Нийт зардал		60,629,653.30	23,665,240.39	36,964,412.92	38.00%
2.1	Цалин	21,719,555.89	13,521,750.99	13,521,750.99	37.70%
2.2	НДШ	2,932,140.08	1,856,242.72	1,856,242.72	36.70%
2.3	Шатахуун	18,211,749.41	11,837,173.34	11,837,173.34	38.40%
2.4	Тосолгооны материал	861,781.07	403,327.63	403,327.63	39.10%
2.5	Сэлбэг хэрэгсэл	1,788,310.35	1,166,364.19	1,166,364.19	34.80%
2.6	Дугуйн зардал	436,008.00	275,165.17	275,165.17	36.90%
2.7	Хөдөлмөр хамгаалал	565,621.56	539,147.22	539,147.22	4.70%
2.8	Үндсэн хөрөнгийн элэгдэл	8,826,292.99	4,608,665.98	4,608,665.98	47.80%
2.9	Бичиг хэрэгсэл	42,216.65	23,352.99	23,352.99	44.70%
2.10	Хангамжийн зардал	56,735.03	40,997.08	40,997.08	27.70%
2.11	Ариун цэврийн зардал	77,117.20	44,674.74	44,674.74	42.10%
2.12	Засвар үйлчилгээ	48,300.00	36,680.14	36,680.14	24.10%
2.13	Цахилгаан	946,746.52	570,170.44	570,170.44	39.80%
2.14	Ус /Бохир соруулал/	30,000.00	15,664.32	15,664.32	47.80%
2.15	Халаалт дулаан	405,343.75	368,821.20	368,821.20	9.00%
2.16	Харилцаа холбоо	58,862.00	54,794.82	54,794.82	6.90%
2.17	Үндсэн хөрөнгийн татаар	-	-	-	0.00%
2.18	Газрын төлбөр	2,814.81	512.12	512.12	82.40%
2.19	Тээврийн хэрэгслийн татаар	29,354.55	16,206.99	16,206.99	44.80%

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000					
2.20	Даатгалын үйлчилгээ	319,262.97	189,973.23	189,973.23	40.50%
2.21	Сургалт, сурталчилгаа	45,130.00	24,430.00	24,430.00	45.90%
2.22	Албан томилолт	40,000.00	11,564.82	11,564.82	71.10%
2.23	Татгаварийн тэтгэмж, буцалтгүй тусламж	530,849.54	334,772.08	334,772.08	36.90%
2.24	Гадны үйлчилгээ	595,632.00	519,540.35	519,540.35	12.80%
2.25	Үйл ажиллагааны бусад	147,898.40	96,463.85	96,463.85	34.80%
2.26	Түрээсийн зардал	438,500.00	146,700.00	146,700.00	66.40%
2.27	Зээлийн хүү /Цахилгаан автобус/	219,889.57	6,293.29	6,293.29	97.10%
2.28	Шимтгэлийн зардал	455,153.00	254,963.13	254,963.13	44.00%
3. Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал		(7,178,238.73)	5,406,073.20	-12,584,311.93	
Орлогын нэг төгрөгт ногдох зардал		1.13	0.81		
Нийт аслага		265,212.6	3,936.28	128,668.04	
Нийт өр төлбөр		28,171,190.6	3,269.07	14,082,326.24	
Хөрөнгө оруулалт		1,096,200.0	6,253.46	541,348.54	

5. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:

"Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын ТУЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 10 дугаар тогтоолоор 2023 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/1643 дугаартай эрх шилжүүлэх тухай захирамжийн дагуу төсвийн хөрөнгө оруулалтаар 600,200.00 мянган төгрөг, Өөрийн хөрөнгө оруулалтаар 14,740,800.00 мянган төгрөг нийт 15,341,000.00 мянган төгрөгийн худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөснөөс гэрээний дүнгээр 10,231,943.784 мянган төгрөгийн худалдан авах ажиллагаа зохион байгуулж ажилласан байна.

Хүснэгт 13

Худалдан авах ажиллагаа 2023 он

(мянган төгрөгөөр)

№	Бараа ажил, үйлчилгээний нэр	Батлагдсан төсөвт өртөг	Гэрээний дүн	ТШДК	Гүйцэтгэгч
1	2	3	4	5	6
Төсвийн хөрөнгө оруулалт					
1	"Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын Нийтийн тээврийн автобус паркийн цахилгаан автобусны цэнэглэгч станцын гадна цахилгаан хангамжийн ажил	600,200.0	589,477.232	НТШЖ	Эрчимхайрхан ХХК
	Дүн	600,200.0	589,477.232		
Өөрийн хөрөнгө оруулалт					
1	Техникийн түргэн тусламжийн машин	60,000.0	59,450.0	ТШОЖ	Балирхангай ХХК
2	Дугуй (7.00R16)	100,000.0	98,845.5	НТШЖ	Балирхангай трейд ХХК
3	Дугуй (295/80R22.5)	200,000.0	187,000.0	НТШЖ	Синержи интернэйшнл ХХК
4	Зуны ажлын хувцас	101,000.0	91,553.0	НТШЖ	Дамен ХХК
5	Шатахуун	8,560,000.0	7,031,427.75	НТШЖ	Шунхлай трейдинг ХХК
6	Өвлийн ажлын хувцас	81,000.0	78,558.5	НТШЖ	Дамен ХХК
7	Даатгалын үйлчилгээ	311,600.0	296,532.103.44	НТШЖ	Агула даатгал ХХК

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000					
1	2	3	4	5	6
8	Цахилгаан автобусны сэлбэг	800,000.0	789,760.075	НТШЖ	Хьюндэй автос ХХК
9	Цэвэрлэгээний материал -	40,000.0	39,953.1	ТШОЖ	Дөлгөөн хангайн тушиг ХХК
10	Багц 1: СХД, 41-р хорооны оффисын цэвэрлэгээний материал	30,000.0	-	-	-
11	Цэвэрлэгээний материал -	80,000.0	72,800.0	НТШЖ	Ви Ай Пи Эс ХХК
12	Харуул хамгаалалтын үйлчилгээ - Багц 2 - "СХД, Тахилт дахь байрны харуул хамгаалалтын үйлчилгээ"	91,000.0	-	-	-
13	Шинэ автобусны сэлбэг - Багц 1 - "XML6105J15C загварын автобусны шил"	120,000.0	95,800.0	НТШЖ	Топ авто шил ХХК
14	Шинэ автобусны сэлбэг - Багц 2 - "XML6105J15C загварын автобусны сэлбэг-1"	97,000.0	96,340.524	НТШЖ	Тоталмаркетинг зйжанси ХХК
15	Шинэ автобусны сэлбэг - Багц 3	183,000.0	-	-	-
16	Тос тосолгооны материал - Багц 1 - Тос тосолгооны материал 1	646,200.0	395,723.0	НТШЖ	Эс Би Жи глобал ХХК
17	Цэнхэр түлш (Adblue)	367,000.0	309,725.0	НТШЖ	Авто ойл ХХК
18	Компьютер, техник хэрэгсэл	125,000.0	-	-	-
19	Каунти автобусны сэлбэг	800,000.0	-	-	-
20	Түлшний нэмэлт нано бодис	406,000.0	-	-	-
21	Чирэгч автомашин	450,000.0	-	-	-
22	Багаж тоног төхөөрөмж	810,000.0	-	-	-
23	Нүүлгэлтийн зардал	120,000.0	-	-	-
24	Бичиг хэргийн материал	55,000.0	-	-	-
25	Засаарын ажилчдын багаж	35,000.0	-	-	-
26	Акумулятор	45,000.0	-	-	-
27	Тавилга, ад хөгшил	27,000.0	-	-	-
	Дүн	14,740,800.0	9,642,466,552		
	Нийт дүн	15,341,000.0	10,231,943.784		

"Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын даргын 2023 оны А/02, А/03, А/04, А/06, А/07, А/14, А/16, А/17, А/18, А/19, А/20, А/30, А/50, А/57 дугаар тушаалуудаар үнэлгээний хороог байгуулан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахыг даалгасан байна.

"Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын даргын тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг ил тод болгож олон нийтийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх зорилгоор, төрийн худалдан авах ажиллагааны

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000

цахим систем www.tender.gov.mn цахим хуудсанд тендерийн баримт бичиг болон урилгыг байршуулж сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, үр дүнг мэдээлсэн байна.

Хүснэгт 14

Худалдан авах ажиллагаа 2024 он

(мянган төгрөгөөр)

№	Бараа ажил, үйлчилгээний нэр	Батлагдсан төсөвт өртөг	Гэрээний дүн	ТШЖ	Гүйцэтгэгч
1	2	3	4	5	6
1	Бичиг хэргийн материал	45,000.0	35,488.26	ТШОЖ	"Грийтийк" ХХК
2	Шатахуун Багц 1	8,000,000.0	7,440,552.0	НТШЖ	"Шунхлайтрейдинг" ХХК
3	Дизель евро-5 хөдөлгүүртэй автобусны шил /Xiamen/ Багц 1	197,000.0	195,300.0	НТШЖ	"Топ авто шил" ХХК
4	Дизель евро-5 хөдөлгүүртэй автобусны сэлбэг /Xiamen/ Багц 2	334,972.0	334,751.1	НТШЖ	"Хьюндэй автос" ХХК
5	Даатгалын үйлчилгээ	320,000.0	274,729.44	НТШЖ	"Ард даатгал" ХХК
6	СХД, 41-р хорооны оффисын цэвэрлэгээний материал Багц 1	50,000.0	41,998.55	ТШОЖ	"Мон Гал Хөгжил" ХХК
7	Хор саармагжуулах нэмэлт бүтээгдэхүүн	24,090.0	23,885.4	ТШОЖ	"Эн Жи Галактик" ХХК
8	Нүүлгэлтийн зардал	60,000.0	59,700.0	ТШОЖ	"Бэйссан" ХХК
9	Автобусны автомат гадна угаалгын төхөөрөмж	200,000.0	196,573.44	НТШЖ	"Ундрахбулаг очир" ХХК
10	Тос тосолгооны материал Багц 1	300,000.0	296,528.51	НТШЖ	"Эрин Монгол интернейшнл девелопмент" ХХК
11	Зуны ажлын хувцас	35,000.0	31,900.0	ТШОЖ	"Даман" ХХК
Нийт дүн		9,566,062.0	8,931,384.7		

2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт 9,566,062.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөснөөс гэрээний дүнгээр 8,931,384.7 мянган төгрөгийн худалдан авах ажиллагаа зохион байгуулж ажилласан байна.

6.АУДИТЫН ҮР ДҮН

Илэрсэн асуудал 1	Хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсан ажилтанд тэтгэмж олгохдоо үндсэн цалингаар бус дундаж цалин хөлсөөр бодож тэтгэвэрт гарсны тэтгэмжид 2023 онд 10 албан хаагчид 13,049.2 мянган төгрөг, 2024 оны эхний хагас жилд 5 албан хаагчид 39,504.37 мянган төгрөг, бүгд 52,553.57 мянган төгрөгийг илүү олгосон.
Асуудлын ангилал	Нөлөө их
Бодит байдал: Хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсан ажилтанд тэтгэмж олгохдоо үндсэн цалингаар биш Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулсан "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын захиргаа болон үйлдвэрчний эвлэлийн хороо хоорондын 2019-2020 онд байгуулсан хамтын гэрээний 2.4.5 дахь "Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-т ажиллаж байгаад өндөр настны тэтгэвэрт гарах эрх үүсч ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд үйлдвэрийн газарт тасралтгүй ажилласан жилээс хамааруулан доорх тэтгэмжийг сарын дундаж цалингаар олгоно" гэсэн заалтыг үндэслэн шийдвэр гарган, дундаж цалин хөлсөөр бодож тэтгэмжийг олгосон. Тус хамтын гэрээнд хуулиас давсан шийдвэрийг тусгасан.	

Байх ёстой шаардлага /шалгуур/:

Хөдөлмөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь "Хамтын гэрээ" гэж тухайн аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны хөдөлмөр эрхлэх, түүнтэй холбогдох эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөдөлмөрийн хууль тогтоомжоор тогтоосон суурь хэмжээнээс дордуулахгүйгээр харилцан тохиролцож ажилтныг илүү таатай нөхцөлөөр хангах, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл, нийгмийн хамгаалалтай холбоотой хуулиар шууд зохицуулаагүй асуудлыг шийдвэрлэхээр ажил олгогч, ажилтны төлөөлөгчийн хооронд байгуулж, зохих журмын дагуу бүртгүүлсэн тохиролцоо", 82 дугаар зүйлийн 82.1.1 дэх "тухайн аж ахуйн нэгж, байгууллагад зургаан сараас хоёр жил хүртэл ажилласан бол нэг ба түүнээс дээш сарын үндсэн цалинтай тэнцэх", 82.1.2 дахь "тухайн аж ахуйн нэгж, байгууллагад хоёр жилээс таа хүртэл жил ажилласан бол хоёр ба түүнээс дээш сарын үндсэн цалинтай тэнцэх", 82.1.3 дахь "тухайн аж ахуйн нэгж, байгууллагад таван жилээс 10 хүртэл жил ажилласан бол гурав ба түүнээс дээш сарын үндсэн цалинтай тэнцэх", 82.1.4 дэх "тухайн аж ахуйн нэгж, байгууллагад 10 ба түүнээс дээш жил ажилласан бол дөрөв ба түүнээс дээш сарын үндсэн цалинтай тэнцэх" гэсэн заалт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаас зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын удирдлагатай байгуулах хариуцлагын гэрээний 3.3 дахь "Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар аливаа гэрээний биелэлт, гүйцэтгэл үр дүнг Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцаж ажиллана" гэснийг зөрчсөн байна.

Асуудлын үндсэн шалтгаан:

Хамтын гэрээний төслийг боловсруулахад хуулийн зөвлөх оролцож, даргын зөвлөлийн хурлаар хянагддаг хэрнээ хуулиас давсан шийдвэрийг тусгаснаас хөрөнгийг үр ашиггүй зарцуулах байдлыг бий болгосон.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Хөрөнгө мөнгийг үр ашиггүй зарцуулах

Зөвлөмж:

Хөдөлмөрийн эрхлэлтийн харилцаа цуцалсан ажилтанд тэтгэмж олгохдоо үндсэн цалингаар тооцон олгох, Хамтын гэрээнд хуулиар шууд зохицуулаагүй асуудлыг тусгах

Илэрсэн асуудал 2	Шатахуунд зарлага болгосон мөнгөн дүн, жолоочийн тооцооны хуудсыг тулган шалгахад 417 литр буюу 996.63 мянган төгрөгийн шатахуунд жолоочийн тооцооны хуудас хөтлөөгүй, ямар ажилд зарцуулсан нь баримтаар нотлогдохгүй байна.
Асуудлын ангилал	Нөлөө их

Бодит байдал:

Жолоочийн тооцооны хуудсыг хөтлөхгүйгээр түлш шатахууныг зарлага болгосон. Нягтлан бодогч нарын ажлыг хүлээлцэхдээ санхүүгийн баримтыг тусган хүлээлцээгүйгээс анхан шатны баримт дутагдах, үрэгдэх эрсдэлийг бий болгож баримтын бүрдэл дутагдсан зөрчлийг бий болгосон.

Байх ёстой шаардлага /шалгуур/:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичигдэж болон цахимаар бичигдэж хийж баталгаажуулна", 14 дүгээр зүйлийн 14.3 дахь "Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ", 14.3.1 дэх "анхан шатны баримт бүрдүүлэх", Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.2 дахь "Ажилтан ажил үүргийг нь гүйцэтгүүлэх зорилгоор олгосон аливаа ажлын багаж, төхөөрөмж, техник хэрэгсэл, эд хөрөнгө, ажил үүргийн дагуу бүрдүүлсэн баримт бичиг, биет болон цахим мэдээлэл, холбогдох бусад зүйлийг нэг бүрчлэн ажил олгогчид хүлээлгэн өгөх үүрэгтэй" гэсэн заалт, Сангийн сайдын 2000 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 69 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Эд хариуцагчийн эрх үйргийн дүрэм"-ийн 1.5 дахь "Эд хариуцагчийн ажлаас халагдах, өөрчлөгдөхөд байгууллагын захиргаанаас томилогдсон комисс түүний хариуцлагад байгаа зүйлийн тооллого тооцоог бүрэн хийж, ...", Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралтаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.4 дэх "НХМаягт ТМ-4 Жолоочийн тооцооны хуудас, Тухайн байгууллагын хөнгөн тэрэг нь ямар албан тушаалтны хэрэгцээнд үйлчилсэн талаархи гүйцэтгэлийг гаргахдаа жолоочийн тооцооны хуудасыг хэрэглэнэ. Хөнгөн тэрэг хэрэглэсэн албан тушаалтан хэдэн км явснаа хянаад гарын үсэг зурна. Тооцоог нягтлан бодогч хийж, нийт дүнгээр түлш, шатахууны хэмнэлт, хэтрэлтийг гаргана" гэснийг зөрчсөн.

Асуудлын үндсэн шалтгаан:

Шат шатны холбогдох албан тушаалтан ажилдаа хариуцлагагүй хандсан байна.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Шатахуун зориулалт бусаар зарцуулагдах

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000

Зөвлөмж:

Түлш, шатахууныг зарцуулахдаа жолоочийн тооцооны хуудсыг бүрэн хөтлөх, Санхүү бүртгэлийн ажилтнуудын ажлыг хүлээлцэхдээ тооллого, тооцоог бүрэн хийж, ажил үүргийн дагуу бүрдүүлсэн баримт бичгийг бүрэн хүлээлцэхэд анхаарч ажиллах.

Илэрсэн асуудал 3	Нийтийн тээврийн автобусны жолооч Жамъян овогтой Пүрэв-Очирын амралтын мөнгөнд 2,392.8 мянган төгрөгийг олгохоор байхад 5,018.6 мянган төгрөгийг олгон, 2,625.8 мянган төгрөгийг илүү олгосон байна.
Асуудлын ангилал	Нөлөө их

Бодит байдал:

Нийслэлийн "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн "Ажилчдын 2023 оны ээлжийн амралтын хуваарь батлах тухай" Б/622 дугаар тушаалаар Ж.Пүрэв-Очирын ээлжийн амралтын хуваарийг 10 сард байхаар баталж, Захиргаа, удирдлага, хүний нөөцийн хэлтсийн дарга 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдөр 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 10-ний өдрийг хүртэлх хугацаанд 27 өдөр амрахаар 133039 дугаар ээлжийн амралт олгох мэдэгдлийг ажилтанд олгож, амралтын мөнгө тооцон олгогдсон байхад дахин 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдөр 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрөөс 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд 27 өдөр амрахаар 133194 дугаар ээлжийн амралт олгох мэдэгдлийг ЗУХНХ-ийн ахлах мэргэжилтэн давхардуулан хийж өгсөнөөс 2 удаа амралтын мөнгийг тооцон, амралтын мөнгөнд 2,625.8 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Байх ёстой шаардлага /шалгуур/:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ын 1.1 дэх "Ажилтны ээлжийн амралт, ээлжийн амралтын цалинг ажил олгогч тооцож олгохдоо Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 99, 110 дугаар зүйл болон холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү журмыг баримтатна", 1.3 дахь "Ажил олгогч ээлжийн амралтын хуваарийн дагуу энэхүү журмын нэгдүгээр хавсралтаар баталсан "Ээлжийн амралт олгох мэдэгдэл"-ийг байгууллагын холбогдох нэгж болон ажилтанд олгоно", Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаас зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын удирдлагатай байгуулах хариуцлагын гэрээний 3.3 дахь "Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар аливаа гэрээний биелэлт, гүйцэтгэл үр дүнг Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцаж ажиллана" гэснийг зөрчсөн.

Асуудлын үндсэн шалтгаан:

ЗУХНХ-ийн ахлах мэргэжилтэн үйлдсэн бичиг баримтыг хянан үзээгүй давхардуулан мэдэгдэл хийсэн, тооцоо болон гүйлгээг хийхдээ холбогдох нягтлан бодогч нар ажилдаа хариуцлагагүй хандсан.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Цалингийн зардал хэтрэх нөлөөтэй

Зөвлөмж:

Ээлжийн амралтын мөнгөн олговрыг бодохдоо анхааралтай, хариуцлагатай ажиллах.

Илэрсэн асуудал 4	Худалдан авах ажиллагааны хэрэгжилттэй холбогдох 14 тендерийн баримт бичгийг тус тусад нь хөтлөх хэрэг бүрдүүлсэн боловч, анхан шатны баримтаас харахад захиалагч баталгаажуулаагүй баримт бичгээр тендер шалгаруулалтыг явуулсан байна.
Асуудлын ангилал	Нөлөө их

Бодит байдал:

Үнэлгээний хороо ТШББ-г захиалагчаар баталгаажуулж ажиллаагүй байна.

Байх ёстой шаардлага (шалгуур): Сангийн сайдын 2021 оны 6 сарын 30-ны өдрийн 103 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орох иргэний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам"-ын 4.10 дахь "Үнэлгээний хороо бараа, ажил, үйлчилгээний онцлогоос хамааруулан төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан жишиг баримт бичигт нийцүүлэн тендерийн урилга, тендерийн баримт бичиг, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлт, тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл зэрэг баримт бичгийг боловсруулж, үнэлгээний хорооны гишүүдийн олонх дэмжсэн баримт бичгийг хууль тогтоомжид нийцүүлэн батлуулахаар захиалагчид хүргүүлнэ" гэснийг зөрчсөн.

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000

Асуудлын үндсэн шалтгаан:

Үнэлгээний хороо ажлын хариуцлага алдсанаас баталгаажуулах баримтаар тендерийн үйл ажиллагааг зохион байгуулсан.

Байгууллагад үзүүлэх нөлөө (үр дагавар): Тогтоосон тоо, хэмжээ, чанарын хувьд доголдол үүсэх, баримт бичиг баталгаажуулаагүйн улмаас хариуцлагыг тогтолцоо алдагдах эрсдэл үүснэ.

Зөвлөмж: Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, ТБОНӨХБАУХАТХууль түүнтэй нийцүүлэн гаргасан жишиг баримт бичиг, журам, аргачлалыг мөрдөж ажиллах.

Цаашид: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх "Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална" гэсэн заалтыг хэрэгжүүлэх

Илэрсэн асуудал 5	Худалдан авах ажиллагааны хэрэгжилттэй холбоотой 2023 оны 14 тендерийн баримт бичгийг хянан үзэхэд 9 тендерийг хянан үзэх, үнэлэх эхний өдөр хурлыг зохион байгуулаагүй, шалтгаан нөхцөл тодорхойгүй хойшлуулж зохион байгуулсан. 4 тендерийг 3 хүртэл хоногтоо хойшлуулах шийдвэр гаргасан ч хугацаандаа зохион байгуулаагүй.
-------------------	--

Асуудлын ангилал	Нөлөө их
------------------	----------

Бодит байдал:

Үнэлгээний хороо 13 тендерийг тендер нээсэн өдөр хянан үзэж, үнэлсэн шийдвэр гаргаагүй байна.

Байх ёстой шаардлага (шалгуур):

Сангийн сайдын 2021 оны 6 сарын 30-ны өдрийн 103 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орох иргэний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам"-ын 4.3 дахь "Энэ журмын 2.25, 2.26-д зааснаар тендер нээх өдөр шинэ үнэлгээний хороо байгуулснаас бусад тохиолдолд үнэлгээний хороо тендер хянан үзэх, үнэлэх эхний хурлыг тендер нээсэн өдөр зохион байгуулна", 4.4 дэх "Зайлшгүй шаардлагатай тохиолдолд энэ журмын 4.3-т заасан тендер хянан үзэх, үнэлэх эхний хурлыг ажлын 3 хүртэл хоногийн хугацаагаар нэг удаа хойшлуулж болно" гэснийг зөрчсөн.

Асуудлын үндсэн шалтгаан:

Нээлтийн тэмдэглэл хөтөлсөн хурлын тэмдэглэлийг баримтжуулж хийдэггүй, аль эсвэл үнэлгээний хороо тендер нээсэн өдөр хурал хийгээгүй байна.

Байгууллагад үзүүлэх нөлөө (үр дагавар):

Ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бий болгосон.

Зөвлөмж: ТБОНӨХБАУХАТХууль түүнтэй нийцүүлэн гаргасан аргачлалыг мөрдөж ажиллах.

Цаашид: ТБОНӨХБАУХАТХ (Шинэчилсэн найруулга) 51 дүгээр зүйлийн 51.2.Үнэлгээний хороо тендер нээсэн өдөр тендер хянан үзэх, үнэлэх ажиллагааг эхлүүлнэ.

Илэрсэн асуудал 6	Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч үнэлгээний хороонд оруулахаар байхад хөндлөнгийн 1 гишүүн оролцуулсан.
-------------------	--

Асуудлын ангилал	Нөлөө их
------------------	----------

Бодит байдал: Зорчигч тэвээр ОНӨТҮААТҮГ-ын даргын 2023 оны А/02, А/03, А/04, А/06, А/07, А/14, А/16, А/17, А/18, А/19, А/20, А/30, А/50, А/50, А/57 дугаар тушаалуудаар үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд хөндлөнгийн нэг гишүүн оролцуулсан байна.

Байх ёстой шаардлага (шалгуур): ТБОНӨХБАУХАТХуулийн 47 дугаар зүйлийн 47.4 дэх "Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотоос бусад орон нутагт аймаг, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна" гэсэн заалтыг зөрчсөн.

Асуудлын үндсэн шалтгаан:

Байгууллагын байршил, худалдан авах ажиллагааны мэргэжлийн хүн дутмаг байдлаас шалтгаалсан.

Байгууллагад үзүүлэх нөлөө (үр дагавар):

Ашиг сонирхлын зөрчил үүсэх.

Зөвлөмж: ТБОНӨХБАУХАТХууль түүнтэй нийцүүлэн гаргасан аргачлалыг мөрдөж ажиллах.

6. ДҮГНЭЛТ

1. Нийслэлийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/688 дугаар захирамжаар 2022, 2023 оны Эдийн засаг, санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшинг тус тус баталсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар өөрийн чиг, үүрэг зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай эд хөрөнгийн жагсаалтыг санхүүгийн жил эхлэхээс 3 сарын өмнө гаргаж, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Сангийн ямаар зардлын дээд хязгаарыг батлуулна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

2. 2023 оны жилийн эцсийн байдлаар өр төлбөр 20,843,743.7 мянган төгрөг байсныг 12,301,088.6 мянган төгрөг болгож 41 хувиар бууруулж, 2024 оны эхний хагас жилийн байдлаар 12,301,088.6 мянган төгрөгөөс 17,741,054.4 мянган төгрөг болгон 56 хувиар өссөн байдалтай байна.

3. Ээлжийн амралтын цалин, тэтгэвэрт гарсан тэтгэмжийг тооцохдоо тооцооллыг холбогдох хууль, журмын дагуу бодож олгоогүйгээс тэтгэмжид 52,553.57 мянган төгрөг, амралтын цалинд 13,402.15 мянган төгрөг, нийт 65,955.72 мянган төгрөгийг илүү олгосон байна.

4. Худалдан авах ажиллагаа, тушаал шийдвэр, ажилтнуудыг ажил хүлээлцэх, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтыг бүрдүүлэхдээ холбогдох хууль журам, мөрдөгдөж байгаа баримт, маягтыг хөтөлж ажиллаагүй байна.

"Зорчигч тээвэр зурв" ОНӨААТҮГ-т хийсэн дотоод аудитаар нийт 69,578.15 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 3,622.43 мянган төгрөгийн улсын ахлах байцаагчийн төлбөрийн акт тогтоон, 65,955.72 мянган төгрөгийн зөрчлийг цаашид даатан заргахгүй байх зөвлөмж хүрээүүлэн, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай дүгнэлт өгч байна.

Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тайлбар
Сайжруулах шаардлагатай	Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь "давамжтай буюу 2-р түвшин"-д байна гэж үзсэн.

5. Нийслэлийн Өмчийн харилцааны газарт Эдийн засаг, санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшинг санхүүгийн жил эхлэхээс 3 сарын өмнө батлах.

АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН
ТАНИЛЦАЖ, ХЯНАСАН:
НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН
АЛБАНЫ ДАРГА
НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН
АЛБАНЫ АУДИТ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА /СХШУБ/
БИЧСЭН:
НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ
АХШХ-ИЙН АХЛАХ ДОТООД
АУДИТОР /СХШУАБ/



З.ОТГОНБАЯР

Ч.ГҮРБАЗАР

О.БАЯРМАГНАЙ

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ
АХШХ-ИЙН АХЛАХ ДОТООД АУДИТОР

Д.МӨНХХАНД

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ
АХШХ-ИЙН АХЛАХ ДОТООД АУДИТОР

Б.МЯГМАРЗАЯА

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ
АХШХ-ИЙН ДОТООД АУДИТОР

М.ХИШИГТ

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ
АХШХ-ИЙН ДОТООД АУДИТОР

Г.ЭНХЧИМЭГ

ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН:
"ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ГУРАВ"
ОНӨААТУГ-ЫН ДАРГА

О.ГАНБААТАР

САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ
НЯГТЛАН БОДОГЧ


Б.БАЯРЦЭЦЭГ

АУДИТЫН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЭРГЭН ХЯНАХ

д/д	Аудитаар өгсөн зөвлөмжийн агуулга	Зөвлөмжийн дагуу удирдлагын авсан арга хэмжээний биелэлт (биелээгүй бол шалтгаан)	Удирдлагын авсан арга хэмжээ хангалтгүй эсэх (тийм/үгүй)	Дараагийн аудитаар анхаарах асуудал байгаа эсэх
1	2	3	4	5
1	2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн дотор Зөрчлийг арилгах төлөвлөгөө гарган ажиллах.			
2	Ээлжийн амралтын цалин, тэтгэмжийг холбогдох хуулийн дагуу тооцож олгох			
3	Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах.			
4	Зөрчил гаргасан ажилтан албан хаагчдын мэдлэг чадварыг сайжруулахаар сургалтад хамруулах.			
5	Дотоод аудитаар илэрсэн зөрчлийг арилган, 3,622.43 мянган төгрөгийн улсын ахлах байцаагчийн актын төлбөрийг хугацаанд нь барагдуулж, зөвлөмжийн хариуг 2025 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлэх.			

ХЯНАСАН:НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН
АЛБАНЫ АУДИТ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА (СХШУБ)

БОЛОВСРУУЛСАН.
НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН
АЛБАНЫ АХШХ-ИЙН
АХЛАХ ДОТООД АУДИТОР

 Д.ГУРБАЗАР

 Д.МӨНХХАНД

8	Хуудсанд авах амжилтааны нэг тэдгээрийг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүртгэлдхүүнд тухайн салбарын мөргөжлийн хөрөнгийн төлөвлөгөө, хуулийн хэргийн, эрхүү тухайн бүс байгууллагын хөрөнгийн доошгүй төлөвлөгөө, хөрөнгийн хороонд оруулжхууль бийжид мөнгөнхөний т гашуун орлогоуулан.	ТЭСНЭХБХАУХАТХүүгийн 47 дугаар зүйлийн 4.7.1 дэх "Хуудсанд авах амжилтааны нэг тэдгээрийг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүртгэлдхүүнд тухайн салбарын мөргөжлийн хөрөнгийн төлөвлөгөө, хуулийн хэргийн, эрхүү тухайн бүс байгууллагын хөрөнгийн доошгүй төлөвлөгөө, хөрөнгийн хороонд оруулжхууль бийжид мөнгөнхөний т гашуун орлогоуулан."	89,576.15	3,622.43	85,955.72
---	--	---	-----------	----------	-----------

Илэрсэн асуудал бүрээр харуу арга хэмжээний төлөвлөгөөний дагуу өгөгдсөн зөвлөх тус бүрд холбогдох талын Нийслэлийн дотоод аудитын албаны хуульчдад ирүүлэхийг мэдэгдэж байна.

ДОТООД АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛТАЙ ТАНИЦАЖ ХҮТЭЭН ДӨРШӨӨРСӨН:

"ЗОРЧИГЧ ТЭЗВЭР ГУРАВ" ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭСИЙН ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ НЯТЛАН БОДОГЧ

ОГЛНЕМАТАР
Б.БАЯРСЭЦЭГ



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАЙН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ДОТООД АУДИТЫН АЛБА
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
АКТ**

Нээгдмэлчин зам 1200, Арцгын өм,

23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,

Улаанбаатар хот, 17100

Утас: (976) 7010 1386, 7010 1408

Цахим шуудан: contact@internalaudit.ub.gov.mn

Цахим хуудас: www.internalaudit.ub.gov.mn

2025.01.06 № 38/09-04

Анхан шатны баримтгүйгээр шатахуунд
зарцуулсан мөнгийг төлүүлэх тухай

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн баталсан 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 15 дугаар удирдамжаар батлагдсан Санхүүгийн хяналт шалгалт болон Дотоод аудитын 2024 оны үйл ажиллагаанд тусгагдсаны дагуу "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын 2023, 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд нийслэлийн Дотоод аудитын албаны аудит, хяналт шалгалтын хэлтсийн Ахлах дотоод аудитор, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Д.Мөнхханд 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн хяналт шалгалтыг хийлээ.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 14 дүгээр зүйлийн 14.3 дахь "Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ", 14.3.1 дэх "анхан шатны баримт бүрдүүлэх", Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралтаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.4 дэх "НХМаягт ТМ-4 Жолоочийн тооцооны хуудас, Тухайн байгууллагын хөнгөн тэрэг нь ямар албан тушаалтны хэрэгцээнд үйлчилсэн талаархи гүйцэтгэлийг гаргахдаа жолоочийн тооцооны хуудасыг хэрэглэнэ. Хөнгөн тэрэг хэрэглэсэн албан тушаалтан хэдэн км явснаа хянаад гарын үсэг зурна. Тооцоог нягтлан бодогч хийж, нийт дүнгээр түлш, шатахууны хэмнэлт, хэтрэлтийг гаргана" гэж заасан.

Жолоочийн тооцооны хуудас хэтлөөгүй 417 литр буюу 998.63 мянган төгрөгийн шатахууныг зарлага болгосон зөрчил илэрлээ

1725040000


ТОГТООХ НЬ:

Нэг. Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг үндэслэн зориулалт бусаар зарцуулсан 996.63 мянган төгрөгийг "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын дарга О.Ганбаатар, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Б.Баярцэцэг, холбогдох албан тушаалтан нараар төлүүлж төсвийг хохиролгүй болгох нь зүйтэй.

Хоёр. Төлбөрийн 996.63 мянган төгрөгийг 9001001 регистрийн дугаартай Нийслэлийн Дотоод аудитын албаны Нийслэлийн Төрийн сангийн УБ.Хүү торгуулийн орлого 100200000968 тоот дансанд 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор оруулахыг "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын дарга О.Ганбаатар, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Б.Баярцэцэг нарт хариуцуулав.

Гурав. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу хяналт шалгалтын шийдвэрийн талаар гомдол гаргах эрхтэй.

АКТ ТОГТООСОН:
НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ
АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ ДОТООД АУДИТОР, САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ



Д.МӨНХХАНД

ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН:
"ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ГУРАВ"
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ
НЯГТЛАН БОДОГЧ

О.ГАНБААТАР

Б.БАЯРЦЭЦЭГ



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРГЭЖҮҮЛЭГЧ АГЕНЦЛАГ

**ДОТООД АУДИТЫН АЛБА
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
АКТ**

Няадламдын зам 1200, Ардатын ям,
23 дугаар хороо, Хая-Уул дүүрэг,
Улаанбаатар хот, 17100
Утас: (976) 7010 1388, 7010 1408
Цахим шуудан: contacts@edamalaudit.ub.gov.mn
Цахим хуудас: www.edamalaudit.ub.gov.mn

2025.01.06 № 38/09-03

Амралтын цалинд илүү олгосон
мөнгийг төлүүлэх тухай

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн баталсан 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 15 дугаар удирдамжаар батлагдсан Санхүүгийн хяналт шалгалт болон Дотоод аудитын 2024 оны үйл ажиллагаанд тусгагдсаны дагуу "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын 2023, 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд нийслэлийн Дотоод аудитын албаны аудит, хяналт шалгалтын хэлтсийн Ахлах дотоод аудитор, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Д.Мөнхханд 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн хяналт шалгалтыг хийлээ.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Эзлжийн амралт олгох, эзлжийн амралтын цалин тооцох журам"-ын 1.1 дэх "Ажилтны эзлжийн амралт, эзлжийн амралтын цалинг ажил олгогч тооцож олгохдоо Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 99, 110 дугаар зүйл болон холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү журмыг баримтлана", Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаас зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын удирдлагатай байгуулах хариуцлагын гэрээний 3.3 дахь "Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар аливаа гэрээний биелэлт, гүйцэтгэл үр дүнг Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцаж ажиллана" гэж заасан.

Нийслэлийн "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн "Ажилчдын 2023 оны эзлжийн амралтын хуваарь батлах тухай" Б/622 дугаар тушаалаар Ж.Пүрэв-Очирын эзлжийн амралтын хуваарийг 10 сард байхаар баталж, Захиргаа, удирдлага, хүний нөөцийн хэлтсийн дарга 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдөр 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 10-ний өдрийг хүртэлх хугацаанд

1725040000

27 өдөр амрахаар 133039 дугаар ээлжийн амралт олгох мэдэгдлийг ажилтанд олгож, амралтын цалин тооцон олгогдсон байхад дахин 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдөр 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрөөс 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд 27 өдөр амрахаар 133194 дугаар ээлжийн амралт олгох мэдэгдлийг ЗУХНХ-ийн ахлах мэргэжилтэн давхардуулан хийж өгсөнөөс 2 удаа амралтын цалин тооцон олгосон байна.

"Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын дарга О.Ганбаатар, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Б.Баярцэцэг нар нь автобусны жолооч Ж.Пүрэв-Очирын амралтын цалинд 2,392.8 мянган төгрөгийг олгохоор байхад 5,018.6 мянган төгрөгийг олгон, 2,625.8 мянган төгрөгийг илүү олгон төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

ТОГТООХ НЬ:

Нэг. Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг үндэслэн зориулалт бусаар зарцуулсан 2,625.8 мянган төгрөгийг "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын дарга О.Ганбаатар, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Б.Баярцэцэг, холбогдох албан тушаалтан нараар төлүүлж төсвийг хохиролгүй болгох нь зүйтэй.

Хоёр. Төлбөрийн 2,625.8 мянган төгрөгийг 9001001 регистрийн дугаартай Нийслэлийн Дотоод аудитын албаны Нийслэлийн Төрийн сангийн УБ.Хүү торгуулийн орлого 100200000988 тоот дансанд 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор оруулахыг "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын дарга О.Ганбаатар, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Б.Баярцэцэг нарт хариуцуулав.

Гурав. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу хяналт шалгалтын шийдвэрийн талаар гомдол гаргах эрхтэй.

АКТ ТОГТООСОН:

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ
АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ ДОТООД АУДИТОР, САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН
"ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ГУРАВ"
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ
НЯГТЛАН БОДОГЧ

Д.МӨНХХАНД

О.ГАНБААТАР

Б.БАЯРЦЭЦЭГ